

ХҮН ХУДАЛДААЛАХ ГЭМТ ХЭРЭГТЭЙ ТЭМЦЭХ, УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХЭД ХИЛИЙН ХЯНАЛТЫН БАЙГУУЛЛАГУУДЫН ОРОЛЦОО

COMBATING HUMAN TRAFFICKING AND PREVENTING PARTICIPATION OF BORDER CONTROL AGENCIES



Х.АСХАР

ХСИС-ийн Хилийн сургуулийн Хилийн боомтын аюулгүй байдлын тэнхимийн дэд профессор, хил судлалын ухааны магистр, хошууч

ASKHAR KH.

Associate professor Border Security Department of Border's Institute of LEU, Master of Borders Studies, Major

Товч утга: Хилийн боомт газар үр дүнтэй хилийн хяналт шалгалтын тогтолцоог хэрэгжүүлснээр хүний наймаа, хууль бус цагаачлал гэмт хэргийн тохиолдлуудыг илрүүлэх, таслан зогсоох, урьдчилан сэргийлэх, мөрдөн шалгах олон улс, бүс нутаг, орон нутгийн шүүх ажиллагааны үндсэн бүтэц болох хүчин зүйлс болох юм. Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэхэд хууль сахиулах байгууллагуудын хамтын ажиллагааны нэг хэлбэр болох сургалтын үйл ажиллагаа нэн чухал юм.

Abstract: The enforcement of effective border monitoring and control at border areas will enable the detection, investigation, cessation and prevention of human trafficking and illegal immigration cases, the key factor for the international, regional and local judiciary process. The collaborative network of law enforcement agencies is crucial in combating with and prevention from human trafficking.

Түлхүүр үгс: Хүн худалдаалах гэмт хэрэг, хилийн хяналт шалгалт, сургалт, хамтын ажиллагаа.
Key words: Human Trafficking, Border Inspection, Training, Cooperation

Дэлхийн хэмжээнд жилд 2 сая 450 мянган хүн ямар нэгэн байдлаар хүний наймаа, албадан хөдөлмөр эрхлүүлэх гэмт хэргийн золиос болж байна гэж хөдөлмөрийн олон улсын байгууллагын судалгаагаар гарсан байна.

Дэлхийн хэмжээний хүний наймаанаас олсон орлого одоогийн байдлаар 44 сая америк доллараар үнэлэгдсэн байна.

Түүний үйл ажиллагааны сөрөг үр дагавар нь дараах байдлаар илэрч байна. Үүнд:

- Зохион байгуулалттай гэмт хэргийн бүлэглэл хоорондын хүчирхийллийн өсөлт нь зах зээл дээр оршин буй албадан хөдөлмөр эрхлүүлэх болон биеэ үнэлүүлэх чиглэлд хүч түрэн тэмцэлдэн хувь эзэмших.

- Зохион байгуулалттай гэмт хэргийн төрөл, хамрах хүрээний өсөлт: зохион байгуулалттай хүний наймаа нь хэзээ ч өөрөө үүсэн бий болдоггүй. Хүний наймааны худалдаа хийж буй худалдаачид нь алан хядах, хар тамхины наймаа, зэвсгийн наймаачидтай өөрт ашигтайгаар ажиллах хоорондын сүлжээг шуурхай бий болгодог.

- Мөнгө угаах гэмт хэргийн улмаас эдийн засгийн зогсонги байдал бий болгох: хүн худалдаалах наймаа нь асар богино хугацаанд их хэмжээний орлогыг олдоогоос улс орны дотоод болон олон улсын хэмжээнд мөнгө угаах гэмт хэргийг

хөгжүүлэх чадамжийг бий болгодог.

- Төрийн байгууллагын хэмжээнд авлигын өсөлт: хүний наймаа, хууль бус цагаачлалын нягт салаа мөчир бүхий зохион байгуулалт нь төрийн бүхий л салбар, байгууллагуудын төрийн албан хаагчдыг өөрийн эрхшээлд оруулах (худалдагдах), энэхүү үйл ажиллагааны үр дагавараар гарах үр дүн нь хууль сахиулах байгууллагаас авлигын эсрэг хийх тэмцэл нь талаар болох магадлалтай байдаг байна.

- Улс төрийн авлига, улс төрийн нөлөөллийг худалдаж авах: дээрх гэмт хэргийн үйл ажиллагаагаа мөнгө санхүүгийн хэрэгсэл ашиглан улс төрийн нөлөөлөл, улс төрийн бодлогыг худалдан авах нь гэмт хэрэгтнүүдэд хувийн ашиг, сонирхлоо хэрэгжүүлэх боломжийг бүрдүүлж болзошгүй.

- Улс орны эдийн засгийн хөгжилд оруулах гадаадын хөрөнгө оруулалтыг зогсонги байдал оруулах: зохион байгуулалттай хууль бус наймаа нь мөнгө угаах гэмт хэргийг халдаах, төрийн байгууллагуудын авлигад автуулснаар улс оронд итгэх итгэлийг үгүй болгосноор гадаад орнуудаас орж ирэх томоохон хөрөнгө оруулагчдаас стратегийн ач холбогдол бүхий хөрөнгө оруулалтад сөрөг нөлөөлөл бий болох магадлалтай.

Хүний наймаа нь ихэвчлэн жендерийн царай төрхний ялгааг харгалзсан шинжтэй байдаг.

Хүний наймаа нь зорилгын хувьд олон янз бөгөөд бүс нутгийн, бүс нутгуудын хэмжээнд, ихэвчлэн гэрийн үйлчлэгч, биеийг нь үнэлүүлэх зорилгоор эмэгтэйчүүд, охидыг хүний наймаанд татан оруулдаг. Хүний наймааны золиос бологсдын ихэнх хувийг хууль бусаар хөдөлмөр эрхлэх цагаачид эзлэх ба ихэвчлэн харгалзах хүнгүй, боловсролын түвшин доогуур, хүний наймаа хийгсэдийн арга залинд хууртагдан мөнгөө алдсан иргэд байдаг.

Ихэнх тохиолдолд эмэгтэйчүүдэд хувийн зорчих баримт бичиг байдаггүй (баримт бичгийг бүрдүүлэхэд гэр бүлийн талаас зөвшөөрөл шаардагддаг). Зорчих баримт бичиггүй аялан яваа эмэгтэйчүүд нь хууль бус цагаачлагч хэмээн нэрлэгдэх ба ихэнхдээ хууль бус үйлдлийн золиос болсон байдаг.

Эрэгтэйчүүд, хөвгүүдийг мөн адил хүний наймааны золиос болгодог. Тэднийг гол нь хөдөө аж ахуй, барилгын, үйлдвэрлэлийн салбаруудад өөрийн хүсэл зорилгын дагуу бус албадлага, боолын хэлбэрээр ажиллуулдаг. Жишээлбэл: тодорхой тохиолдлыг нэрлэвэл Баруун Африкт хилчид авлига аван олон тооны хөвгүүдийг боол болгон худалдаалах зорилготойгоор улсын хилээр хууль бусаар хил нэвтрүүлсэн явдал юм. Жендерийн ялгааг харгалзан улсын хилээр шалган нэвтрүүлэх үйл явц нь хүний наймааны золиос болох үйлдлийг илрүүлэх боломжийг бүрдүүлж байгаагаас гадна хүний наймаа, хууль бус цагаачлалын золиос бологсдыг хамгаалах шаардлагатай арга хэмжээ гэж үзэж байна.

Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх талаар дагаж мөрдөх хууль тогтоомж, дүрэм, зааврыг хамтран боловсруулснаар нэгдсэн, цогц бодлогыг хангадаг.

Энэхүү үйл ажиллагаанд оролцох янз бүрийн байгууллагуудын хоорондын уялдаа холбоо, хамтын ажиллагаа, боловсруулах ажлын бүлгүүдэд орох гүйцэтгэх ажилтнуудыг хууль, хяналтын байгууллагууд ихэвчлэн хариуцан томилдог. Үүнээс гадна хилийн хяналт шалгалтын байгууллагуудаас өөр хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх чиглэлээр ажиллаж буй дараах байгууллагууд ордог. Үүнд.

- Цагдаагийн тусгай салбар;
- Эмнэлэгийн шинжээчид (шүүх эмнэлэгийн шинжээч, хүүхдийн асран

хамгаалах алба, эмэгтэйчүүдийг хамгаалах алба, хохирогчид тусламж үзүүлэх байгууллага, хохирогчдод өмгөөлөл үзүүлэх, хууль зүйн зөвлөгөө өгөх байгууллага ба бусад хувийн байгууллагууд);

- Төрийн бус байгууллагууд гэх мэт.

Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх талаар үндэсний хэмжээнд төрийн байгууллагууд хүний наймааны золиос болж буй хүмүүсийн эрхийг хамгаалахад өөрийн үүрэг чиглэлээ биелүүлэхдээ иргэний болон төрийн бус байгууллагуудын төлөөлөлтэй хамтран үйл ажиллагаагаа явуулдаг.

Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх тогтолцоог практик амьдралд хамтран ажиллах хэрэгсэл болж төлөвлөн ажилласан тохиолдолд илүү үр дүнтэй. Хамтран ажиллах үед төрийн байгууллага, иргэний болон төрийн бус байгууллагуудын үүрэг оролцоо, тэдний хариуцан ажиллах бүс хэсгүүдийг тогтоож, хамтран ажиллах дүрэм, заавруудыг мөрдлөг болгож ажиллах нь зүйтэй. Хүний наймаанаас урьдчилан сэргийлэх, илрүүлэх ажиллагааг амжилттай хэрэгжүүлэхийн тулд тухайн төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх байгууллагаас энэ чиглэлээр байнгын мэдээ, мэдээллийг цуглуулахад хилийн боомт бүхий гарцууд нь мэдээ мэдээллийг цуглуулах, ашиглах чухал объект болдог.

Эдгээр хүчин зүйлсээс хамааран хилийн хяналт шалгалт, аюулгүй байдлыг хангах чиг үүрэг бүхий байгууллагуудын алба хаагчдад хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх талаарх сургалтыг байнга хийх нь үр дүнгээ өгдөг нь гадаадын улс орнуудын туршлагаас харагдаж байна.

Сургалтын ач холбогдол нь суралцагчдын талаар урьдчилсан байдлаар практик мэдлэгийн түвшинд дүн шинжилгээ, тэдний эрэлт хэрэгцээ зэргийн үр дүнг сургалтын хөтөлбөрт хэрхэн боловсруулж тусгаснаас хамаарна.

Сургалтын агуулга нь бодит нөхцөл байдал, практик түвшинд нийцсэн, эрэлт хэрэгцээг хангасан, хоорондоо уялдаа холбоотой байна.

Сургалтын суралцах явцын график төлөвлөгөө, үргэлжлэх хугацааг тогтоох шаардлагатай.

Сургалтыг идэвхтэй болгох янз бүрийн арга барилууд байдаг. Оновчтой сургалтын арга барилыг сонгоход дотоод нөөц боломж, суралцагчдын албан тушаал, цол хэргэм, мөн тодорхой нөхцөл байдалд тавигдах шаардлагуудаас шууд хамааралтай байдаг.

Сургалтын чадамж нь сургалтад ноогдох хугацаа, хөрөнгө төсөв эсвэл зарим сургалтын хувилбараар явуулахаас хамаарна. Үүнд: танилцах дадлага, ажилтнуудаа солилцох, зааварчилгаа, дугуй ширээний ярилцлага, дадлага, ажлын байранд тавигдах зөвлөмж, зааварчилгаа гаргах зорилгоор удирдлагын түвшинд шинжээчдийг ажиллуулах гэх мэт.

Сургалтын ач холбогдлыг нэмэгдүүлэхэд нэмэлт арга хэмжээг авч болно. Үүнд:

Ажилчдыг шагнаж урамшуулах, эрэгтэй, эмэгтэйчүүдийн бүрэлдэхүүний дунд, жендерийн онцлогт харгалзан бүртгэл судалгааг явуулсан байдалд амжилт гаргасан, мөн шагнаж урамшуулсан талаар мэдээллийн хэрэгслээр зарлан мэдээлэх зэрэг болно.

Хилийн хяналтын байгууллагуудын албан хаагчдад сургалтыг зохион байгуулж явуулах зөвлөмж, саналууд

- Жендерийн бүртгэлийг “агаарын орон зай” гэсэн байдлаар авч үзэхгүй

байх. Хилийн хяналтын байгууллагуудын алба хаагчид магадгүй албан үүргээ биелүүлэх үед энэхүү арга хэмжээг хэрхэн хийх талаар тайлбарлаж өгснөөр боддог.

- Жендерийн тулгамдсан асуудал нь онцгой тусгай сэдэв мэтээр ойлгох бус хилийн хяналтын байгууллагуудын албан хаагчыг сургах гол холбоос сургалт гэдгээр ойлгох, мөн жендерийн онцлогт тулгуурласан тусгай хичээлээс бусад бүх сургалтын хөтөлбөрт жендерийн асуудлын талаар оруулна.

- Орон нутгийн онцлогийг тусгасан сургалтын материаллаг баазыг сонгож авах.

- Сургалтад оролцож байгаа бүрэлдэхүүний албан тушаал, зэрэг дэв, тодорхой бүлгүүдийн онцлогийг харгалзан үзэж, уг сургалтын материалын агуулга нь практик даалгаврыг биелүүлэх, шийдвэр гаргах түвшинд байхаар сургалтад заах материалдаа тодотгол хийнэ. Жишээлбэл: удирдах албан тушаалтнуудын бүрэлдэхүүний суралцагчдад жендерийн онцлогийг харгалзан бүртгэлийг хийх хүрээнд эрх зүйн баримт бичиг, заавар боловсруулах дадлагын даалгавар гүйцэтгүүлэх, дундаж түвшиний удирдлагуудад жендерийн тулгамдсан асуудлыг шийдвэрлүүлэх даалгавар өгөх, харин гүйцэтгэх албаны ажилтнуудад тодорхой цагийн байдал үүсэн үед жендерийн онцлогийг харгалзан бүртгэлийг явуулах дадлагын арга барилыг сургах.

- Эмэгтэйчүүд, иргэний нийгмийн байгууллагаас авагдсан орон нутагт тулгамдаж буй асуудал, жишээ баримт, олон талын үзэл бодол зэрэг мэдээллийг эх сурвалж болгон ашиглана.

- Сургалтад ахлах офицерыг оролцуулснаар тухайн сургалтад онцгой ач холбогдол өгөх боломж бүрдэнэ.

Давтан сургалтыг байнга явуулж, чанартай болгох үүднээс суралцагчдын талаар тодорхойлолт, үр дүнг тодорхойлох үнэлгээ зэргийг өгөхөд анхаарах.